



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Зэрэг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/08/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Ховд хот

2023 он

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545

Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn

Аудитор: Л.Галбадрах

Утас:

Цахим хаяг: Galbadrakh@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	9
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	9
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	10
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	12
4. АУДИТЫН ТАЙЛАН	14
4.1 Ерөнхий зүйл	14
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	16
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ӨХЗ	Өмч хамгаалах зөвлөл
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ГХУСЗЗ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл
ХХС	Хоршоо хөгжүүлэх сан



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

ЗЭРЭГ СУМЫН ТӨСВИЙН
ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ Б.БАТБИЛЭГ ТАНАА

2023.03.23 № 02/109
танай _____ -ны № _____ -т

ХЯЗГААРЛАЛТТАЙ ДҮГНЭЛТ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Зэрэг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Зэрэг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар төсвийн хөрөнгөөс хандив тусламж олгосон, ОНХС-гийн журмыг зөрчиж хөтөлбөр арга хэмжээний зардлыг санхүүжүүлсэн, татварын орлогын төлөвлөгөөг тасалсан, бараа материал, үндсэн хөрөнгийн тооллого хийгээгүй, өмнөх аудитын зөвлөмж хэрэгжүүлээгүй зэрэгтэй холбоотой 131.9 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, АДБОУС 1250, иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Зэрэг сумын татварын орлогын гүйцэтгэл 401.1 сая төгрөг буюу 28.6 сая төгрөгөөр тасарсан байна. Орлого давсан шалтгаан нь цалин хөлс, шагнал урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого 60.6 сая төгрөг, хөрөнгө борлуулсны албан татвар 2.4 сая төгрөг, үйл ажиллагааны албан татвар 0.7 сая төгрөг, хог хаягдлын үйлчилгээний хураамж 0.4 сая, байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр 0.3 сая төгрөг, дуудлага худалдаа сонгон шалгаруулалт 7.6 сая төгрөг, ус, рашаан ашигласны 0.1 сая төгрөг, түгээмэл тархацтай ашигт малтмал 0.1 сая төгрөгөөр тус тус орлого давуулан биелүүлж, хөрөнгийн орлого 5.2 сая, шууд бус орлого 29.6 сая, үл хөдлөх хөрөнгийн албан татвар 0.1 сая төгрөг, бууны албан татвар 0.4 сая төгрөг, малын тоо толгойн албан татвар 31.7 сая, газрын төлбөр 1.0 сая, улсын тэмдэгтийн хураамж 1.2 сая төгрөг, хүү торгууль 0.8 сая төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлого 0.3 сая төгрөгөөр тус тус тасалжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,289.3 сая төгрөг буюу 87.9 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 5.5 сая, бараа үйлчилгээний бусад зардал 0.2 сая

021020413

төгрөг, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлыг 0.5 сая, байр ашиглахтай холбоотой зардал 0.1 сая, хөрөнгийн зардал 170.7 сая нийт 177.0 сая төгрөгийг зарцуулаагүй мөнгөн хөрөнгийн дансанд үлдсэнтэй холбоотой байна.

Аудитын гол асуудал

Өмнөх онуудад төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн тайланд нэгтгэгддэг байсан Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Эрүүл мэндийн төв, Соёлын төвийн санхүүгийн тайлангийн тогтмол зардлаас бусад үзүүлэлтүүд системийн дээд байгууллагын тайланд нэгтгэгдэх бодлогын өөрчлөлт бий болсонтой холбоотойгоор эдийн засгийн гол үзүүлэлтүүдэд нөлөөлөл бүхий өөрчлөлтүүд орсон байна.

Бусад асуудлын хэсэг

Сумын ЗДТГ нь 5 зорилтын хүрээнд 63 арга хэмжээ төлөвлөсөн бөгөөд хэрэгжилтийг 96.7 хувьтай үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	/ мянган төгрөгөөр/	
		2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	635,142.3	609,661.3
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	141,996.4	231,534.2
32	БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	0.0	0.0
33	АВЛАГА	248,376.3	279,211.0
34	УРЬДЧИЛГАА	0.0	0.0
35	БАРАА МАТЕРИАЛ	244,769.6	88,916.2
36	НӨӨЦИЙН БАРАА	0.0	10,000.0
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	0.0	0.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	10,824,771.0	4,443,224.5
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	10,824,771.0	4,443,224.5
39100	Газар	0.0	0.0
39200	Биет хөрөнгө	10,761,329.4	4,436,532.8
39300	Биет бус хөрөнгө	63,441.6	6,691.7
39400	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	0.0	0.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	11,459,913.2	5,052,885.8
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	11,298.4	26,941.7
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	11,298.4	26,941.7
41300	Өглөг	11,298.4	26,941.7
41400	Урьдчилж орсон орлого	0.0	0.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	11,448,614.9	5,025,944.0
51	Засгийн газрын хувь оролцоо	11,448,614.9	5,025,944.0
51100	Засгийн газрын оруулсан капитал	3,048,385.8	494,395.7
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	0.0	0.0
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	0.0	494,395.7
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	10.0	0.0
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	3,000.0	0.0
51200	Хуримтлагдсан үр дүн	7,513,573.4	4,445,696.0
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	883,645.6	85,852.3
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	11,459,913.2	5,052,885.8

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	6,692,100.50	1,410,623.40
11	ТАТВАРЫН ОРЛОГО	144,502.40	401,117.40
110	Орлогын албан татвар	53,385.00	248,021.10
1100	Хувь хүний орлогын албан татвар	53,385.00	248,021.10
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0	0
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	0	0
1103	ААН-ын орлогын албан татвар	0	0
1104	Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар	0	0
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	0	0
113	Хөрөнгийн албан татвар	4,528.40	59,154.90
114	Нэмэгдсэн өртгийн албан татвар	0	0
115	Онцгой албан татвар	0	0
116	Тусгай зориулалтын орлого	0	0
117	Гадаад үйл ажиллагааны орлого	0	0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	86,589.10	93,941.40
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,606,288.60	79,710.00
120	Нийтлэг татварын бус орлого	3,606,288.60	79,710.00
121	Хөрөнгийн орлого	0	0
122	Тусламжийн орлого	0	0
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0	0
124	Зээлийн орлого	0	0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,941,309.50	929,796.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,251,559.00	1,800,834.20
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,251,559.00	1,800,834.20
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,117,036.70	1,777,789.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,797,709.30	387,713.20
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	244,691.60	47,786.90
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	244,187.00	318,400.40
2104	Хангамж, бараа материалын зардал	223,501.10	275,792.40
2105	Нормативт зардал	192,261.80	0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,318.80	4,477.70
2107	Томилолт, зочны зардал	4,059.00	3,208.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	28,360.40	24,471.80
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	369,947.80	715,939.00
211	ХҮҮ	0	0
212	ТАТААС	0	0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	134,522.30	23,044.70
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0	0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	3,440,541.50	-390,210.70
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	0	0
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	2,704.50	5,945,441.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	3,437,837.10	-6,335,651.70

2.3 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	3,385,266.60	1,746,988.80
11	ТАТВАРЫН ОРЛОГО	144,502.40	401,117.40
110	Орлогын албан татвар	53,385.00	248,021.10
1100	Хувь хүний орлогын албан татвар	53,385.00	248,021.10
113	Хөрөнгийн албан татвар	4,528.40	59,154.90
118	Бусад татвар, төлбөр, хураамж	86,589.10	93,941.40
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	5,350.00	3,941.30
1181	Газрын төлбөр	1,169.00	8,648.80
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	80,070.00	81,351.30
1183	Бусад татвар	0	0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	365,317.00	422,732.40
120	Нийтлэг татварын бус орлого	365,317.00	422,732.40
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,875,447.20	923,139.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,105,168.80	1,248,186.90
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,105,168.80	1,248,186.90
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,956,829.60	1,195,102.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,924,496.30	534,163.30
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	274,127.50	71,680.10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	350,667.70	463,442.80
2104	Хангамж, бараа материалын зардал	74,257.00	30,664.20
2105	Нормативт зардал	196,866.60	335.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,053.10	4,732.10
2107	Томиллолт, зочны зардал	4,063.70	3,226.10
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	65,095.30	37,081.60
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	57,202.40	49,776.70
211	ХҮҮ	0	0
212	ТАТААС	0	0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	148,339.20	53,084.70
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	280,097.80	498,801.90
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	0	0
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	204,402.20	309,264.10
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	204,402.20	309,264.10
2200	Дотоод эх үүсвэрээр	204,402.20	309,264.10
2260	Гадаад эх үүсвэрээр	0	0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-204,402.20	-309,264.10
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0	-100,000.00
14	Бусад эх үүсвэр	0	0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	0	100,000.00
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	0	0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	75,695.60	89,537.80
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	66,300.70	141,996.40
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	141,996.4	231,534.2

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн өмчийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	8,010,334.80	8,010,334.80
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	2,537.90	2,537.90
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	8,012,872.70	8,012,872.70
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-2,094.90	-2,094.90
9	Тайлант үеийн үр дүн	3,437,837.10	3,437,837.10
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	11,448,614.90	11,448,614.90
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	11,448,614.90	11,448,614.90
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-87,019.10	-87,019.10
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	11,361,595.80	11,361,595.80
19	Тайлант үеийн үр дүн	-6,335,651.70	-6,335,651.70
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	5,025,944.00	5,025,944.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

1	Тайлангийн үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
2	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	1,466,335.2	1,289,277.7
3	Урсгал зардал	917,209.4	885,862.6
4	Бараа, ажил үйлчилгээний зардал	839,124.7	832,777.9
5	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	392,048.6	387,704.8
6	Ажил өлгөчөөс нийгмийн даатгалд төлөх шимтгэл	48,530.4	48,398.3
7	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	319,875.3	318,910.1
8	Хангамж, бараа материалын зардал	22,224.0	22,021.7
9	Нормативт зардал	335.3	335.3
10	Эд хогшил, урсгал засварын зардал	4,732.1	4,732.1
11	Томилолт, зочны зардал	3,381.8	3,381.8
12	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,548.5	7,000.8
13	Бараа үйлчилгээний бусад зардал	40,448.7	40,448.7
14	Урсгал шилжүүлэг	78,084.7	53,084.7
15	Засгийн газрын урсгал шилжүүлэг	55,000.0	30,000.0
16	Бусад урсгал шилжүүлэг	23,084.7	23,084.7
17	Хөрөнгийн зардал	449,125.8	303,415.1

18	Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	100,000.0	100,000.0
19	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	1,466,335.2	1,375,123.4
20	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,344,227.0	1,306,432.4
21	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	122,108.2	68,691.0
22	Мөнгө, түүнтэй адилдах хөрөнгийн эхний үлдэгдэл		110,447.6
23	Мөнгө, түүнтэй адилдах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		196,293.3

2.6 Аудит хийсэн нэгтгэсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	251,825.5	32,975.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	210,404.1	32,975.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	148,217.0	25,518.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	9,178.8	
210201	Ажил олгогчоос нийгмийн даатгал төлөх шимтгэл	4,060.0	
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	500.0	
2104	Хангамж, бараа материалын зардал	4,875.3	1,503.8
2105	Нормативт зардал	87,659.0	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,235.0	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	33,836.9	8,837.6
210901	Бараа үйлчилгээний бусад	5,872.1	15,177.0
1310	Урсгал шилжүүлэг		7,457.3
1310	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		7,457.3
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	251,825.5	32,975.6
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	251,825.5	32,975.6
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,452.0	13,677.6
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	71,507.3	8,089.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		11,209.0
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	124,402.7	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Зэрэг сумын Засаг дарга нь Монгол улсын Үндсэн хууль болон УИХ, Засгийн газраас гарч буй хууль тогтоомжид нийцүүлэн “Орон нутгийн хөгжил дэвшилд манлайлагч байж мэдлэг чадварт суурилсан нутгийн захиргааны мэргэшсэн байгууллага байх” эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон дараах зорилтыг тавин ажилласан байна. Үүнд:

- ✓ Хууль тогтоомж, хөгжлийн бодлого, стратеги зорилт, шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохин байгуулж хяналт тавих
- ✓ Баг байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулж, мэргэшил арга зүйн удирдлагаар хангах
- ✓ Хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэх ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохин байгуулах
- ✓ Тамгын газрын үйл ажиллагааг удирдан зохин байгуулах, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах тайлагнах, хяналт тавих
- ✓ Хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг
- ✓ Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, цахим систем нэвтрүүлж, иргэдийн цаг хугацаа зардлыг хэмнэх
- ✓ Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх арга хэмжээ,
- ✓ Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх арга хэмжээ

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль зэрэг хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд 2022 онд нэмэлт өөрчлөлтүүд орсон байна. 2022 онд нь Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд 4 удаа, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд 1 удаа, Төсвийн тухай хуульд 6 удаа, Шилэн дансны тухай хуульд 1 удаагийн өөрчлөлт орж Төрийн хэмнэлтийн тухай хууль шинээр батлагдан мөрдөгдөж эхэлсэн байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

Зэрэг сумын Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Засаг даргын дэргэдэх санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас хяналт шалгалт 2019-2021 оны баримтууд хамрагдсан байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Зэрэг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг *аккруэл* сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Сумын нэгтгэсэн санхүүгийн тайланд мөрдөх тусгайлан баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй бөгөөд Сангийн яамнаас гаргасан бодлого шийдвэрүүдийг хэрэгжүүлэн и-баланс цахим программ хангамж ашиглан холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцүүлэн, үйл ажиллагааны онцлогт тохируулан ашиглаж байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Зэрэг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 6,413.7 сая төгрөгөөр буюу 40 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

Тайлангийн үзүүлэлтүүд	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/	
			Өөрчлөлт	
Мөнгөн хөрөнгө	141.9	231.5	-89.6	61%
Авлага	248.3	195.2	52.8	127%
Урьдчилгаа		84	-84	0%
Бараа материал	244.7	88.9	155.8	275%
Үндсэн хөрөнгө	10,824.70	4443.2	6381.5	244%
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	11,459.90	5052.9	6407	227%
Богино хугацаат өр төлбөр	11.3	26.9	-15.6	42%
Цэвэр хөрөнгө, өмч	11448.6	5025.9	6422.7	228%
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	11,459.90	5052.8	6407.1	227%

Эх сурвалж: Зэрэг сумын ТТЗ-ын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Дээрх хүснэгтээс харахад, *санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлттэй мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилгаа, үндсэн хөрөнгийн дансууд байна.*

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 141.9 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 231.5 сая төгрөг болж 89.6 сая төгрөгөөр буюу 61 хувиар өсөхөд зарцуулагдаагүй үлдсэн ОНХС-гийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нөлөөлжээ. Дээрх мөнгөн хөрөнгөөс 57.3 сая төгрөг нь ОНӨААТҮГ-ийн арилжааны банк дахь дансанд үлдэх 174.2 сая төгрөг нь Төрийн сангийн дансанд байршиж байна.

3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 195.2 сая төгрөг болж, өмнөх оноос 52.8 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Авлагын үлдэгдэл /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
----------	----------------	-----------------	------------------------

Байгууллагаас авах авлага	86.1	93.4	-7.3
Хувь хүмүүсээс авах авлага	162.3	186.5	-24.2
Дүн	248.4	279.9	-31.5

Эх сурвалж: Зэрэг сумын ТТЗ-ын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага 31.5 сая төгрөгөөр буурсан нь Эрүүл мэндийн төвийн даатгалын санхүүжилт, ОНХС-ийн барьцаа 5 хувийн авлагаар тус тус буурсан байна. Тайлант онд хоршоо хөгжүүлэх сангаас нэмж 100.0 сая зээл олгож 68.3 сая төгрөгийн зээлийн авлагыг барагдуулсан байна. Мөн улсын төсвийн байгууллагуудын балансыг шилжүүлсэнтэй холбоотой Ерөнхий боловсролын сургуулийн балансд бүртгэлтэй 13.0 сая төгрөгийн авлага шилжиж барагдуулсантай холбоотой өөрчлөгдсөн байна.

3.4.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эцсийн үлдэгдэл 84.0 сая төгрөг болж өссөн байна.

Хүснэгт 3. Урьдчилгаа дансны үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	0.0	84.0	84.0
Тусгай зориулалтын сан			-
Дүн	0.0	84.0	84.0

Эх сурвалж: Зэрэг сумын ТТЗ-ын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Зэрэг сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар "Төв болон Далан үнээ тавьтын гэрэлтүүлэг, Цэцэрлэгийн хашаа" -2022-Ажил-05,07,351 дугаартай гэрээний дагуу 84.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгож тухайн ажлыг улсын комисс хүлээж аваагүй урьдчилж гарсан зардал дансанд бүртгэсэнтэй холбоотой аудитаар нэмж бүртгэн залруулсан.

3.4.4 Бараа материал

Бараа материалын дансны үлдэгдэл 88.9 сая төгрөг болж 155.8 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 4. Бараа материал дансны үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлтүүд	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	
Түүхий эд материал	30.4	0.0	-30.4	0.0
Тусгай зориулалттай материал	0.0	0.00	0.0	0.0
Эм боох материал	30.4	0.00	-30.4	0.0
Бэлэн бүтээгдэхүүн				
Хангамжийн материал	203.4	80.2	-123.2	0.3
Бичиг хэргийн материал	5.07	1.82	3.24	0.3
Аж ахуйн материал	24.7	11.8	12.9	0.4
сэлбэг хэрэгсэл	2.4	7.3	4.8	2.9
Түлш шатах тослох материал	16.6	23.3	6.7	1.4
Барилгын засварын материал	3.4	0.0	-3.4	0.0
Хүнсний материал	15.5	0.00	-15.5	0.0
Бусад хангамжийн материал	135.59	35.59	-99.63	0.3
Мал амьтад	8.6	8.6	0.0	0.0
Нөөцийн бараа	0	10.01	-10.0	1.0
Нийт бараа материал	244.76	88.91	-155.8	0.3

Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 92.3 сая төгрөгийн бараа материал бэлтгэж, аймгаас буцаан олгох нөхцөлтэйгөөр 10.0 сая төгрөгийн өвс тэжээлийн нөөц бүрдүүлж, 57.8 сая төгрөгийн материалыг зарцуулж, 180.3 сая төгрөгийн бараа материалыг улсын төсвийн байгууллагуудын балансаас балансаж шилжүүлсэнтэй холбоотой өөрчлөлт орсон байна.

3.4.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 13635.4 сая төгрөг байсан бол оны эцэст 6150,9 сая төгрөг болж 7534.3 сая төгрөгөөр буурсан 7534.3 сая төгрөгийн хөрөнгийг балансаас балансад шилжүүлж 1769,2 сая төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой буурсан байна.

3.4.6 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 11.3 сая, эцсийн үлдэгдэл 26.9 сая төгрөг болж 15.6 сая төгрөгөөр өссөн байна. Тайлант хугацаанд аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс буцаан олгох нөхцөлтэйгөөр 10.0 сая төгрөгийн санхүүжилт авч тэжээл бэлтгэсэнтэй холбоотой өглөг бүртгэн, ОНХС-гаар хэрэгжүүлсэн гэрээт ажлын барьцаа хөрөнгийн өр төлбөрийг бүртгэсэнтэй холбоотой байна.

3.4.7 Цэвэр хөрөнгө, өмч

Засгийн газрын оролцоо дансны оны эхний үлдэгдэл 3,048.4 сая төгрөг байснаас оны эцэст 494.4 сая төгрөг болж 2553.9 сая төгрөгөөр буурсан нь Ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэг, Эрүүл мэндийн төвийн баланс шилжсэнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,536.0 сая төгрөгөөр, нийт зарлагыг 1,536.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Зэрэг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны нэгтгэсэн төсвийг аймгийн ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 15 өдрийн 5/01 тоот тогтоолоор 1,536.0 сая төгрөгөөр анх баталж өмнө оны болон тайлант оны давсан орлого болон Төрийн үйлчилгээний албан хаагчийн ТҮ1-4 хоорондох цалинг улсын төсөвт шилжүүлсэнтэй холбоотойгоор 2022 онд 1 удаа тодотгол хийн 2022 оны 06 дугаар сарын 22-ны 07/01 тоот тогтоолоор нийт 1,466.3 сая төгрөгөөр баталсан байна.

Төсвийн тодотголыг сумын ИТХ-аар 2022 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн 7/01 тоот тогтоолоор 69.7 сая төгрөгөөр бууруулан тодотгож баталжээ.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 1,466.3 сая төгрөгийн төсөв баталснаас 501.9 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 473.1 сая төгрөг татварын болон татварын бус орлогоос, ОХНС-аас санхүүжих 394.9 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос, 12.0 сая төгрөгийг туслах үйл ажиллагаанаас/СХС-гийн зээлийн эргэн төлөлт/ санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Хүснэгт 5. Нийт орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл сая төгрөгөөр

Сум байгуул лагын нэрс	Төсвийн орлого		Давсан орлого	Санхүүгийн дэмжлэг		Санхүүгийн дэмжлэгийн өөрчлөлт	Нийт урсгал орлого		Урсгал орлогын өөрчлөлт	Мөнгөн хөрөнгө		Төсвийн зарлага	Зардлын өөрчлөлт			
	төл	гүй		төл	гүй		төл	гүй		Эхний үлдэг дэл	Эцсийн үлдэгд эл			өөрчлө лт	төл	гүй
Зэрэг	557.5	404.5	153.0	501.9	507.3	(5.4)	1,059.4	911.8	147.6	26.2	21.7	4.5	1,059.4	911.8	147.6	
ХХС	12.0	68.4					12.0	68.4		88.9	57.3		12.0	100.0		
ОНХС				394.9	394.9	-	394.9	394.9	-	21.5	138.9	(117.4)	394.9	277.5	117.4	
	569.5	472.9	153.0	896.8	902.2	(5.4)	1,466.3	1,375.1	147.6	136.6	217.9	(112.9)	1,466.3	1,289.3	265.0	

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 501.9, орон нутгийн татварын болон татварын бус орлого 404.6, ОНХС-ийн санхүүжилт 394.9, үндсэн үйл ажиллагааны орлогоос 0.3, туслах үйл ажиллагааны орлого буюу сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт 68.3, урьд оны үлдэгдлээс 109.5 сая төгрөг нийт 1,375.15 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,289.3 сая төгрөгийг зарцуулж 1.6 сая төгрөгийг орон нутгийн ерөнхий орлогод буцаан төвлөрүүлжээ.

Үндсэн үйл ажиллагааны орлогыг 0.6, туслах үйл ажиллагааны орлого 12.0 сая төгрөгөөр тус тус батлагдаж гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагааны орлогыг 0.3 сая, туслах үйл ажиллагааны орлого буюу сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөс 68.3 сая төгрөг нийт 68.6 сая төгрөгийн орлого бүрдүүлснээс үзэхэд сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийн орлогыг хэт бага төлөвлөсөн байна.

Хүснэгт 6. Сумын татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая.төгрөг/

Орлогын ангилал	2022 оны		Зөрүү
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
Татварын нийт орлогын дүн	434.4	404.6	(29.7)
Нийт орлого ба тусламжийн дүн	434.4	404.6	(29.7)
Татварын орлого	429.7	401.1	(28.6)
Орлогын албан татвар	219.0	245.6	26.6
Хувь хүний орлогын албан татвар	219.0	245.6	26.6
Цалин, хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогын	135.1	195.7	60.6
Үйл ажиллагааны орлого	20.0	20.7	0.7
Хөрөнгийн орлого	32.0	26.8	(5.2)
Шууд бус орлого	31.9	2.2	(29.6)
Хөрөнгийн албан татвар	91.4	61.5	(29.9)
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	2.7	2.5	(0.15)
Хөрөнгө борлуулсан албан татвар		2.4	2.4
Бууны албан татвар	4.3	3.9	(0.4)
Малын тоо толгойн албан татвар	84.4	52.6	(31.7)
Бусад татвар, төлбөр, хураамж	119.2	93.9	(25.3)
Улсын тэмдэгтийн хураамж	1.9	0.7	(1.2)
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны	1.1	1.2	0.1
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	1.5	1.9	(0.4)
Газрын төлбөр	1.9	0.9	(1.0)
Дуудлага худалдаа	-	7.6	7.6
Байгалийн нөөц ашигласны төлбөр	1.0	1.3	0.3

Ан амьтны нөөц ашигласны төлбөр	111.1	79.3	(31.8)
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	0.5	0.6	0.1
Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	1.0	1.3	0.3
Татварын бус орлого	4.6	3.4	(1.2)
Нийтлэг татварын бус орлого	4.6	3.4	(1.2)
Хувьцааны ногдол ашиг	-	-	-
Торгуулийн орлого	4.0	3.1	(0.9)
Төсөвт байгууллагын өөрийн орлого	0.6	0.3	(0.3)

Эх сурвалж: Зэрэг сумын ТТЗ-ын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт орлого 404.6 сая төгрөг буюу 29.7 сая төгрөгөөр дутуу бүрдүүлжээ. Орлого давсан шалтгаан нь цалин хөлс, шагнал урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого 60.6 сая төгрөг, хөрөнгө борлуулсны албан татвар 2.4 сая төгрөг, үйл ажиллагааны албан татвар 0.7 сая төгрөг, хог хаягдлын үйлчилгээний хураамж 0.4 сая, байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр 0.3 сая төгрөг, дуудлага худалдаа сонгон шалгаруулалт 7.6 сая төгрөг, ус, рашаан ашигласны 0.1 сая төгрөг, түгээмэл тархацтай ашигт малтмал 0.1 сая төгрөгөөр тус тус орлого давуулан биелүүлж, хөрөнгийн орлого 5.2 сая, шууд бус орлого 29.6 сая, үл хөдлөх хөрөнгийн албан татвар 0.1 сая төгрөг, бууны албан татвар 0.4 сая төгрөг, малын тоо толгойн албан татвар 31.7 сая, газрын төлбөр 1.0 сая, улсын тэмдэгтийн хураамж 1.2 сая төгрөг, хүү торгууль 0.8 сая төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлого 0.3 сая төгрөгөөр тус тус тасалжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн тайлангаар аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 10 сая төгрөг, Шим –Ус ОНӨААТГ-аас 5.2 сая төгрөг, байгаль хамгаалах сангаас 3.2, статистикийн хэлтсээс 1.1 сая, аймгийн ЗДНХ-өөс 0.2 сая, ГХУС33-өөс 1.0 сая төгрөг, урьд оны татан төвлөрүүлэлт 6.7 ОНХС-гаас барьцаа хөрөнгө 7.4 сая төгрөг нийт 32.9 сая төгрөгийг төвлөрүүлэн бараа үйлчилгээний бусад зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал дансанд тайлагнан үйл ажиллагаандаа зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Зэрэг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, санхүү нягтлан бодох бүртгэл, хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг аудитор Л.Галбадрах 2023 оны 03 дугаар сарын 10-ны өдрөөс 03 дугаар сарын 23-ний хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 06-ний өдрийн 1/49 албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэллээ.

Материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлж, материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоож, нийт зардлын суурь үзүүлэлтээс тооцож төлөвлөлтийн материаллаг байдлыг 35.6 сая төгрөгөөр тогтоож баримтжууллаа.

Мөн санхүүгийн тайлангийн түвшинд гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар букуу 28.4 сая төгрөгөөр тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлсэн тул зөрчил бүртгэн зөвлөмж өглөө.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд тендерт шалгарсан оролцогчийн мэдээлэл, ЗДТГ, ИТХ, Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлсэн таван сая төгрөгөөс дээш орлого, зарлагын гүйлгээг бүрэн мэдээлсэн бөгөөд төсөв өмч хөрөнгө зарцуулахтай холбоотой шийдвэрийн мэдээллийг мэдээлээгүйг аудитын явцад залруулан цахим системд мэдээлүүллээ. Түүвэрт хамрагдсан СХС-гийн зээл олгосон 100.0 сая төгрөг, ЗДТГ-ын 5.0 сая төгрөгөөс дээш орлогыг мэдээлүүлэн залруулсан.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх аудитаар өгөгдсөн 1.0 сая төгрөгийн 1 төлбөрийн акт барагдаж 203.1 сая төгрөгийн 2 албан шаардлагаас 15.9 сая төгрөгийн тээврийн хэрэгслийн ашиглалттай холбоотой

албан шаардлага хэрэгжээгүй, 122.4 сая төгрөгийн 5 зөвлөмж өгөгдсөнийг 42 хувьтай хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 7. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	1	2	1	0	0	100%
Албан шаардлага	3	219	2	203.1	1	15.9	93%
Зөвлөмж	8	122.4	4	52	4	70.4	42%
Нийт дүн	7	169.3	7	169.3	-	-	78

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сум хөгжүүлэх сангаас зээл олгогдож хугацаа хэтэрсэн 17 иргэний 61.5 сая төгрөгийн асуудлыг шүүхэд шилжүүлсэн байгаа тул дараа онд хэрэгжилтийг хянан үзэх шаардлагатай гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 97.7 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 638.0 сая төгрөгийн алдааг залрууллаа.

Үүнд:

- **Хууль тогтоомжтой холбоотой:** Түүвэрт хамрагдсан СХС-гийн зээл олгосон 111.4 сая төгрөг, ЗДТГ-ын 5.0 сая төгрөгөөс дээш орлогын 335.1 сая төгрөг, нийт 546.5 сая төгрөгийн орлого, хөрөнгө зарцуулахтай холбоотой шийдвэрийг Шилэн дансны цахим системд мэдээлээгүй байсан нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл заасан заалтыг зөрчсөн тул мэдээлүүлэн залруулсан.
- ✓ **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:** ОНХС-гаас хэрэгжүүлсэн барьцаа хөрөнгийн 7.5 сая төгрөгийн өр төлбөрийг тусгаагүй, "Төв болон Далан үнээ тавьтын гэрэлтүүлэг, Цэцэрлэгийн хашаа" -2022-Ажил-05,07,351 дугаартай гэрээний дагуу 84.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгож тухайн ажлыг улсын комисс хүлээж аваагүй байхад зардлаар бүртгэсэн тул аудитаар урьдчилж гарсан зардал дансанд бүртгэн залруулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-т "Аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх" заалтыг зөрчсөн байна.

Аудитаар нийт 131.9 сая төгрөгийн зөрчил² илэрч зөрчлийг арилгах 3 зөвлөмж өгсөн.

5.1 Зөвлөмж

5.1.1 Авлагын данстай холбоотой

Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн тооллого хийгээгүй хөрөнгийн бүртгэлд байгаа 4 трактор тооллого хийгээгүй, 1 авто тээврийн хэрэгсэл ашиглалтгүй өмнөх оны аудитын

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

зөвлөмж хэрэгжээгүй няравтай тооцоо нийлж баталгаажуулаагүй, бараа материалын тооллого хийгээгүй, эхний үлдэгдэл орших хөрөнгийн жагсаалт байхгүй /бичиг хэрэг 1.4 сая, сэлбэг 1.7 сая, аж ахуйг 35.3 сая тооллого тооцоо бодоогүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5."Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж : Үндсэн хөрөнгө, бараа материалын тооллого тооцоо хийж хөрөнгийн бүртгэлд тавих дотоод хяналтыг сайжруулж ажиллах

5.1.2 ОНХС-ийн зарцуулалттай холбоотой асуудал

Илрүүлэлт ОНХС-гаас иргэдийн санал аваагүй, эрэмбэлэхгүйгээр дэд хөтөлбөрүүдэд 14.1 сая төгрөгийг зарцуулсан нь ь Төсвийн тухай хууль 60 дугаар зүйлийн 60.3.6-д "орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх", 60.3.4.-д "нийтийн эрх ашигт нийцээгүй үйл ажиллагаа, 60.3.1.орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргээс бусад хөтөлбөр, арга хэмжээ, ОНХС -ийн үйл ажиллагааны журмын 4.3.2.-д "ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь тухайн орон нутгийн иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдсэн байх" 4.2.4.Аливаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд олгох буцалтгүй тусламж, дэмжлэг, тэтгэмж, урамшуулал" гэсэн тэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хууль тогтоомжийн заалтыг хэрэгжүүлж ажиллах, ИРГэдийн санал аваагүй төсөл арга хэмжээг санхүүжүүлдэг байдлыг таслан зогсоох

5.2.3 Төсвийн хөрөнгө зарцуулалттай холбоотой асуудал

Илрүүлэлт: ЗДТГ-ын засаг даргын нөөц хөрөнгөнөөс Төрийн хэмнэлтийн тухай хуулийн зөрчин хандив тусламжид 5.8 сая төгрөгийн олгосон байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.3.хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгохыг хориглох заалтын хэрэгжилт хангагдаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Төрийн хэмнэлтийн хуулийг мөрдөж ажиллах, Төсвөөс хандив тусламж олгохыг таслан зогсоох

5.2.4 Орлогын бүрдүүлэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Нийт орлого 404.6 сая төгрөг буюу 29.7 сая төгрөгөөр дутуу бүрдүүлжээ. Тасарсан орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл хөрөнгийн орлого 5.2 сая, шууд бус орлого 29.6 сая, үл хөдлөх хөрөнгийн албан татвар 0.1 сая төгрөг, бууны албан татвар 0.4 сая төгрөг, малын тоо толгойн албан татвар 31.7 сая, газрын төлбөр 1.0 сая, улсын тэмдэгтийн хураамж 1.2 сая төгрөг, хүү торгууль 0.8 сая төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлого 0.3 сая төгрөгөөр тус тус тасалжээ.

Өгсөн зөвлөмж: Орон нутгийн орлогыг оновчтой төлөвлөн орлогыг нэр төрлөөр нь бүрэн биелүүлэн ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 6 дүгээр сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан	
								Дүн
Шилэн дансны хуульд заасан мэдээллэлийг мэдээллээгүй	2	546.5	2	546.5			2	546.5
Авлага, өр төлбөр зөрүүтэй илэрсэн	2	91.4	-	-	2.0	91.4	2.0	91.4
Дүн	4.0	637.9	2.0	546.5	2.0	91.4	4.0	637.9

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Үүнээс			
	Нийт алдаа		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үндсэн хөрөнгийн тооллого хийгээгүй хөрөнгийн бүртгэлд байгаа 4 трактор тооллого хийгээгүй, 1 авто тээврийн хэрэгсэл ашиглалтгүй өмнөх оны аудитын зөвлөмж хэрэгжээгүй Хөрөнгийн тооллого хийгээгүй, эхний үлдэгдэл орших хөрөнгийн жагсаалт байхгүй /бичиг хэрэг 1.4 сая, сэлбэг 1.7 сая, аж ахуйг 35.3 сая тооллого тооцоо бодоогүй	1	82.3	1	82.3
Орлогын гүйцэтгэлд тавих хяналт сул, зарим нэр төрлийн орлого тасарсан.	1	29.7	1	29.7
Дүн	2	112.	1	112.0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс	
			Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн
ЗДТГ-ын данснаас Төрийн хэмнэлтийн тухай хуулийн зөрчин хандив тусламж олгосон	1	5.8	1	5.8
ОНХС-гаас иргэдийн санал аваагүй 14.1 сая төгрөгийн дэд хөтөлбөр гаргасан,	1	14.1	1	14.1
Нийт дүн	2.0	19.9	2.0	19.9

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР